



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/93

Мандатговь

2020 оны "Оны онцлох хүүхэд" шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 9 дүгээр зүйлийн 9.1.6, 14 дүгээр зүйлийн 14.1.7, 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн шууд захирагчаас Төрийн жинхэнэ албан хаагчтай байгуулсан 2020 гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өөрийн мэдлэг, авъяас хичээл зүтгэлээрээ тэргүүлэн сурлага, спорт, урлагаар амжилт гарган манлайлсан хүүхдийг олон нийтэд алдаршуулах, хүүхдийн хөгжих нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, үе тэнгийн хүүхэд багачуудад үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор 2020 оны "Оны онцлох хүүхэд"-ийг 9 төрлөөр шалгаруулсугай.

2. 2020 оны "Оны онцлох хүүхэд" шалгаруулах удирдамжийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар, бэлтгэл ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. 2020 оны "Оны онцлох хүүхэд"-ийг шагнаж урамшуулах үйл ажиллагаанд зарцуулагдах 654.300 (Зургаан зуун тавин дөрвөн мянга гурван зуун) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Бүжинлхам), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч (Б.Бүжинлхам)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

431190287

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
А/193 дугаар тушаалын 22 дүгээр хавсралт



2020 ОНЫ "ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД" ШАЛГАРУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Энгэрийн тууз	ш	12000	9	108000
2	Өргөмжлөл	ш	26000	9	234000
3	Бэлэг	ш	25000	9	225000
4	Бэлэгний уут	ш	3500	9	31500
5	Авъяас медаль	ш	5700	9	51300
6	Үнэмлэх	ш	500	9	4500
Нийт					654.300

----oOo----